



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 78

Сүхбаатар сум

Бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч
хувь хүний албан татварын хувь хэмжээ
тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "д", 25 дугаар зүйлийн 25.1, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.4.1, 21.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхэлж орлого олж байгаа хувь хүний орлогод сард ногдуулах албан татварын хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхэлж орлого олж байгаа иргэдэд тавих хяналтыг сайжруулж бүртгэлжүүлэн татварын орлогыг бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан ажиллахыг аймгийн Татварын хэлтэс /Д.Цэрэнболд/-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар ханган биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.


4.Энэхүү тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА



Г.БЯМБАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн
78 дугаар тогтоолын хавсралт



БИЧИЛ ХУДАЛДАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ХУВЬ ХҮНИЙ АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Д/д	Эрхлэх үйл ажиллагааны төрөл	Албан татварын хувь хэмжээ /тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тзоцох/	Сард ногдуулах албан татварын хэмжээ /төгрөгөөр/
Хувиараа зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн			
1	Алтанбулаг хилийн боомтоор улс хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх /4 хүртэл хүний суудалтай автомашинаар/	5%	21000
2	Алтанбулаг хилийн боомтоор улс хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх /5-12 хүртэл хүний суудалтай автомашинаар/	10%	42000
Автобус /зорчигчийн тоо/			
1	Алтанбулаг хилийн боомтоор улс хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх /13-с дээш хүртэл хүний суудалтай автобусаар/	15%	63000
Улс хоорондын ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх ачааны автомашин /даацын хэмжээ/			
1	Алтанбулаг хилийн боомтоор улс хоорондын ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх /3.5 тонн хүртэлх даацтай автомашин/	10%	42000
2	Алтанбулаг хилийн боомтоор улс хоорондын ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх /3.5-12 тонн хүртэлх даацтай автомашин/	15%	63000
3	Алтанбулаг хилийн боомтоор улс хоорондын ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх /13-19 тонн хүртэлх даацтай автомашин/	20%	84000
4	Алтанбулаг хилийн боомтоор улс хоорондын ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх /20-с дээш тонн даацтай автомашин/	25%	105000
Хот, аймаг, сум хооронд зорчигч болон ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх			
1	Хот, аймаг, сум хооронд зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэх	5%	21000

2	Хот, аймаг, сум хооронд ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх	10%	42000
3	Хот, аймаг, сум хооронд уул уурхайн ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх	20%	84000
Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн			
1	Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын хэмжээнд ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй, ил задгай худалдаа үйлчилгээ эрхлэх	2%	8400
2	Бусад суманд ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй, ил задгай худалдаа ажил үйлчилгээ эрхлэх	1%	4200

